

САВЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТООН ХЭМЖЭЭНД ХЭМЖИЛ ЗҮЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэ журмын зорилго нь төрөл бүрийн сав, баглаа боодолтой үйлдвэрлэх, худалдах, импортлох бүтээгдэхүүний (цаашид “савласан бүтээгдэхүүн” гэнэ) тоон хэмжээнд төрийн хэмжилзүйн хяналт, шалгалт хийх мөн үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжилзүйн ажилтнуудаас тавих хяналт, шалгалтын үйл ажиллагааг тогтооно.

Төрөл бүрийн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүнийг савлан худалдах үед тавих тоон хэмжээний хэмжилзүйн хяналтыг хэмжил зүйн хяналтын улсын байцаагчид (цаашид улсын байцаагч гэнэ) гүйцэтгэнэ. Үйлдвэрлэлийн хэмжил зүйн ажилтнууд дотоод хяналтыг энэхүү журмаар тогтоосон арга зүйн дагуу хэрэгжүүлж болно. Хяналт, шалгалтад мэргэжлийн байгууллагууд болон хэрэглэгчдийн нийгэмлэгийн төлөөлөгчдийг татан оролцуулж болно.

ХОЁР. НЭР ТОМЬЁО ТОДОРХОЙЛОЛТ

Энэ журамд хэрэглэсэн дараах нэр, томьёог дор дурьдсан утгаар ойлгоно

Савласан бүтээгдэхүүн- Бүтээгдэхүүний тоон хэмжээг урьдчилан тогтоож, өөрчлөх боломжгүйгээр битүүмжилсэн бараа материалыг

Тайлбар: Анхдагч нэгж сав буюу боодлыг –“сав боодол”, тэдгээрийг агуулсан хоёрдогч баглаатай (авдар, хайрцаг гэх мэт) бүтээгдэхүүнийг “савласан” гэж ойлгоно.

Цэвэр тоон хэмжээ (М)- Сав, баглаа боодолд агуулагдаж байгаа бүтээгдэхүүний бодит тоон хэмжээг

Тайлбар: Бүтээгдэхүүний бодит тоон хэмжээг сав баглаа боодол дээр “Цэвэр жин...”, “Цэвэр эзэлхүүн...” гэж тэмдэглэнэ.

Хэвийн тоо хэмжээ (М)- Сав баглаа боодолтой бүтээгдэхүүний нийт тоон хэмжээг **Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хэмжилзүйн хяналт, шалгалт**- Сав, баглаа боодолд агуулагдсан бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээ нь бодит тоон хэмжээтэй нийцэж буйг тогтоох, сав боодол дээрх мэдээлэл стандартын шаардлагад нийцэж байгааг тогтоох, шалгах үйл ажиллагаа

Цуврал бүтээгдэхүүн- Технологийн нэг удаагийн шат дамжлагаас гарсан, багц бүтээгдэхүүнийг

Тайлбар : Цуврал бүтээгдэхүүнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийхдээ нэг газарт, нэг цаг хугацаанд, нэг ижил аргаар хийж гүйцэтгэнэ. Шалгалтад хамрагдах цуврал бүтээгдэхүүний шинж чанар, тоон хэмжээг тодорхойлох зорилгоор санамсаргүй аргаар түүвэрлэн авсан савласан бүтээгдэхүүн (n) нь цуврал бүтээгдэхүүнийг бүрэн төлөөлнө.

Сав, баглаа боодлын хаяг, шошго- Тухайн савласан бүтээгдэхүүний шинж чанар, тоон хэмжээ, агуулга, орц найрлага, үйлдвэрлэсэн огноо, үйлдвэрлэсэн газар,

хадгалах хугацаа, хадгалах горим, тээвэрлэлтийн горим, хэрэглэх арга зэрэг үндсэн мэдээллийг хэрэглэгчид өгөх зорилгоор бичсэн, хэвлэсэн, графикаар үзүүлсэн, хавсаргасан, наасан, цутгасан, товойлгосон байдлаар бүтээгдэхүүний сав баглаа боодолд дагалдах баримт.

ГУРАВ. САВЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТООН ХЭМЖЭЭНД

ТАВИХ ХЭМЖИЛ ЗҮЙН ШААРДЛАГА, ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Худалдахад бэлэн болгосон сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Савласан бүтээгдэхүүн тус бүрийн хэвийн тоон хэмжээ (M) цэвэр тоон хэмжээний (m) утгын зөрүү нь тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичиг, техникийн нөхцөл, стандартад заасан тоон хэмжээний хэвийн утгын зөвшөөрөх хэлбэлзэл (T)-ээс ихгүй байна. Хэрэв норматив баримт бичигт өөрөөр заагаагүй бол савласан бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээний хэлбэлзэл (T) нь хэвийн тоон хэмжээний зөвшөөрөх хэлбэлзлээс их байвал уг сав, боодлыг тэнцэхгүйд тооцно.

- Тухайн бүтээгдэхүүний баримт бичигт тоон хэмжээний зөвшөөрөх хэлбэлзлийн хязгаар (T)-ыг заагаагүй тохиолдолд MNS OIML R 87 стандартын дагуу сонгон авна.

Тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичигт өөрөөр заагаагүй бол савласан цуврал бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээний дундаж утга нь хэвийн тоон хэмжээний утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн (T) хүрээнд байх ёстой.

- Шаардлагад тэнцэхгүй савласан бүтээгдэхүүний тоо (Cp) нь норматив баримт бичгээр тогтоосон түүвэр дэх тэнцэхгүй савласан бүтээгдэхүүний зөвшөөрөх тоо (C)-оос илүүгүй байвал тухайн цуврал бүтээгдэхүүнийг тэнцсэн гэж үзнэ.

- Хэмжил зүйн хяналт, шалгалтын үед савласан бүтээгдэхүүний сав, баглаа боодол тус бүрийн цэвэр тоон хэмжээ(m), тухайн бүтээгдэхүүний тоон хэмжээний (M) хэвийн утгын зөвшөөрөх хэлбэлзэл (T)-ийн 1/5-ээс ихгүй алдаатай хэмжинэ.

Тайлбар: Онцгой тохиолдолд хэмжлийн алдаа нь тоон хэмжээний хэвийн утгын зөвшөөрөх хэлбэлзэл (T)-ийн 1/3-ээс ихгүй байж болох ба хэмжлийн алдааг ихэсгэсэн үндэслэлийг шалгалтын үр дүнгийн тайланд тэмдэглэнэ.

3.2 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд тавих хэмжилзүйн хяналт, шалгалт нь дараах хэлбэртэй байна.

Үүнд:

- Төлөвлөгөөт хяналт шалгалт
- Төлөвлөгөөт бус хяналт шалгалт
- Гүйцэтгэлийн хяналт шалгалт

3.3 Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд тавих хэмжил зүйн хяналт, шалгалтыг MNS OIML R 87 “Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээ” стандартын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд үйлдвэрлэлийн технологийн процессод үзүүлэх нөлөө, зардлыг аль

болохоор бага байлгах, шалгалтад хамрагдсан бүтээгдэхүүнийг гэмтээхгүй байхаар зохион байгуулна.

Тайлбар: Хэрэв сав, баглаа боодлын тоон хэмжээ тодорхой буюу түүнийг шалгалтын явцад тодорхойлж болох бол түүнд савласан бүтээгдэхүүний цэвэр тоон хэмжээний утгыг сав, баглаа боодлыг онгойлгож гэмтээлгүйгээр шууд бус аргаар тодорхойлно.

- Хэмжил зүйн хяналт, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шалгалтын удирдамж, зорилго, хугацааг танилцуулна.

- Хэмжилзүйн хяналт, шалгалтад хамрагдах савласан бүтээгдэхүүний нэрсийг тодорхойлно.

- Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд тавигдах шаардлагыг тогтоосон стандарт, норматив техникийн баримт бичигтэй танилцана.

- Хаяг, шошго стандартын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Тайлбар: Түүвэр сонгох, цэвэр тоон хэмжээг хэмжих, хэмжлийн үр дүнг боловсруулах, дүгнэлт гаргах үйл ажиллагаа нь энэхүү журмын 3; 4 заалтын шаардлагатай харшлахгүй бол тухайн бүтээгдэхүүний стандарт, норматив техникийн баримт бичгийн дагуу хийж болно.

3.4 Хэмжилзүйн хяналт, шалгалтын үед савласан бүтээгдэхүүний түүврийг, савлалтын дамжлага болон савласны дараа, түүнчлэн бэлэн бүтээгдэхүүний агуулахаас сонгон авч болно. Цувралын хэмжээ нь үйлдвэрлэгчийн савлах үйл ажиллагааны тухай бүрэн, зөв мэдээлэл өгөхөд хүрэлцэхүйц байвал зохино.

Тайлбар: Хэрэв нэг цувралын хэмжээ нь хяналт шалгалтын үр дүнг үнэн бодитой гаргахад хүрэлцэхгүй гэж үзвэл ижил төрлийн хэд хэдэн цувралыг нэгтгэж нэг цуврал болгож болно.

3.5 Савласан бүтээгдэхүүний цувралаас түүвэрлэн авахдаа, нийт цуврал бүтээгдэхүүний аль ч нэгж адил магадлалтай сонгогдох аргыг хэрэглэнэ.

Түүврийн хэмжээг тодорхойлох:

- Савласан бүтээгдэхүүний сав, боодол бүр нь өөр өөр тоон хэмжээний хэвийн утгатай бол шалгалтад 10-аас доошгүй сав, боодлыг сонгон авна.

- 150-иас доош нэгж агуулсан савласан бүтээгдэхүүний цувралаас авах түүврийн хэмжээ нь 20 хувиас багагүй байна.

- 150-иас дээш нэгж агуулсан савласан бүтээгдэхүүний цувралаас авах түүврийн хэмжээ (n)-г дараах томъёогоор тодорхойлж авна:

$$n = 30 + 0.0125N \quad (1)$$

Тайлбар: N- савлагааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц цувралын хэмжээ

Сав, баглаа боодлыг нь эвдэхгүйгээр доторх бүтээгдэхүүний тоон хэмжээг шалгах арга байхгүй тохиолдолд хоёр буюу олон шатлалтай шалгалт явуулах зэргээр түүврийн хэмжээг багасгаж болно.

Тайлбар: Түүврийн хэмжээг үндэслэлгүй багасгах нь шалгалтын үр дүнгийн үнэн зөв байдал буурч стандартын шаардлага хангахгүй болдог.

3.6 Савласан бүтээгдэхүүнээс авсан түүврийн сав, баглаа боодол тус бүрийн цэвэр тоон хэмжээ (m)-г хэмжинэ. Хэмжлийн үр дүнг тайланд тусгана.

3.7 Шалгалтаар тэнцээгүй бүтээгдэхүүнийг тусгай таних тэмдэг ()-ээр тэмдэглэж, тэнцээгүй бүтээгдэхүүний тоо (Cp) нь тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичигт заасан тэнцээгүй бүтээгдэхүүний зөвшөөрөх тоо (C)-ноос их гарвал тухайн цуврал бүтээгдэхүүнийг тэнцэхгүй цуврал бүтээгдэхүүн гэж тооцон илэрсэн зөрчлийг “акт”,

“заавал биелүүлэх шаардлага”-д заан уг зөрчлийг арилгах хүртэл борлуулахыг хориглоно.

Тухайн бүтээгдэхүүний норматив баримт бичигт хэмжлийн үр дүнг боловсруулах аргачлал тусгагдаагүй бол цуврал бүтээгдэхүүний тоон хэмжээний дундаж утгын хэмжлийн үр дүнгийн боловсруулалтыг “В” **хавсралт**ын дагуу хийж, түүнээс гарах дүгнэлтийг шалгалтын тайланд бичнэ.

3.8 Шалгалтын үр дүнгээс дүгнэлт, шийдвэр гаргах.

3.9 Шалгалтын үр дүн, дүгнэлт нь “Хэмжил зүйн тухай” Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагад нийцэхгүй энэ нь худалдан авагч, хэрэглэгчийг хохироосон нь баримтаар нотлогдвол зүй бусаар олсон орлогыг дараах томъёогоор тооцож акт үйлдэнэ.

Озб= ΔХз Үн;

Озб- тоон хэмжээний дутуугаас олсон зүй бус орлого, төг;

Δ- нэгж сав, баглаа боодлоос дутсан тоон хэмжээ;

Хз – дутуу савлагаатай дүгнэлтэд хамрагдах ёстой гэж баримтаар нотлогдсон сав, баглаа боодлын нийт тоо, ширхэг;

Үн – бүтээгдэхүүний нэгж тоон хэмжээний (г, мл) үнэ, төгрөг;

3.10 Хэрэв шалгалтын явцад бусад баримт материалыг тодруулан шалгахад илэрсэн зөрчил нь зөвхөн нэг удаагийн шинжтэй (бүтээгдэхүүнийг борлуулаагүй гэх мэт) хэрэглэгч, худалдан авагчийг хохироогоогүй бол цуврал бүтээгдэхүүнийг борлуулахыг зогсоож, зөрчлийг арилгуулах “Заавал биелүүлэх шаардлага” өгнө. Зөрчлийг арилгасаны дараа түүнийг борлуулахыг зөвшөөрнө.

ДӨРӨВ. САВ БАГЛАА БООДЛЫН ХАЯГ, ШОШГОНД ТАВИХ ХЯНАЛТ

4.1 Сав баглаа боодлын хаяг шошго нь хэрэглэгчдийг төөрөгдүүлэхгүй, бодит үнэн зөв байна.

4.2 Сав, баглаа боодлын хаяглалтанд тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрийн хаяг байршил, үйлдвэрлэсэн огноо, дуусах хугацаа, тээвэрлэх заавар, хадгалалтын заавар, хэрэглэх заавар, орц найрлага, мөрдсөн стандартын нэр, цэвэр болон бохир жинг заавал бичсэн байна. Шаардлагатай тохиолдолд сав, баглаа боодлын шинж чанарыг тодорхойлсон байна.

4.3 Сав баглаа боодлын хаяг, шошгон дээр бүтээгдэхүүний тоон хэмжээг Олон Улсын нэгжийн Си системийн нэгжээр тэмдэглэнэ.

Тайлбар: импортоор оруулж ирж байгаа бүтээгдэхүүн нь үйлдвэрлэгч улсын дотоод дүрэм журмын дагуу тэмдэглэгдсэн бол Монгол хэл рүү хөрвүүлэн нэмэлт наалт хийж болно.

4.4 Сав баглаа боодлын хаяг шошго нь MNS OIML R 79” Савласан бүтээгдэхүүний шошгонд тавих шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.

ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН БҮРДҮҮЛЭЛТ

5.1 Төрөл бүрийн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээг савлах ба худалдах үед шалгасан үр дүн, илэрсэн зөрчлийг шалгалтын тайланд бичнэ.

5.2 Хяналт шалгалтад оролцсон хүмүүс шалгалтын тайланд гарын үсэг зурах ба үүний дараа нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглоно.

5.3 Хяналт шалгалтад оролцсон хүмүүсийн санал зөрсөн тохиолдолд эцсийн шийдвэрийг ажлын хэсгийн ахлагч гаргана.

5.4 Шалгагдаж буй аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчид гарсан дүгнэлтийг зөвшөөрөхгүй бол өөрсдийн саналыг бичиж дүгнэлтэд хавсаргана.

5.5 Шалгалтын тайланг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулах бөгөөд дүгнэлтийг зөвшөөрөхгүй тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллага энэ тухай тайлбараа бичиж өгөх эрхтэй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1 Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг, даалгаврыг улсын байцаагч өгөх ба шаардлагын биелэлтийн хариуг заавал бичгээр авна.

6.2 Зөрчил гарсан тохиолдолд “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Хэмжил зүйн тухай” хууль, Монгол Улсын бусад хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**САВЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТООН ХЭМЖЭЭНИЙ ЗӨВШӨӨРӨХ
ХЭЛБЭЛЗЛИЙН ХЯЗГААР**

1-р хүснэгт

Тоон хэмжээний хэвийн утга М (г, мл)	Зөвшөөрөх зөрүү (Т)	
	М-ээс хувиар, %	г, мл
5-аас 50 хүртэл	9	-
50-иас 100 хүртэл	-	4,5
100-аас 200 хүртэл	4,5	-
200-аас 300 хүртэл	-	9
300-аас 500 хүртэл	3	-
500-аас 1000 хүртэл	-	15
1000-аас 10000 хүртэл	1,5	-

Тоон хэмжээний хэвийн утга М (кг буюу л)	Зөвшөөрөх зөрүү (Т)	
	М-ээс хувиар, %	г, мл
15-50	1,0	-
50-100	-	500
100-аас дээш	0,5	-

Т-ын утгыг М<1000 г (мл)-т аравны нэг бутархайгаар, М>1000 г (мл)-т бүхэл нэгжээр тус тус нарийвчилна.

2-р хүснэгт

**САВ, БАГЛАА БООДОЛТОЙ САВЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТҮҮВЭР ДЭХ
ТЭНЦЭХГҮЙ САВ, БООДЛЫН ЗӨВШӨӨРӨГДӨХ ТОО С**

Цувралын хэмжээ N	Шалгахаар авсан түүвэр дэх тэнцээгүй сав, баглаа боодлын зөвшөөрөх тоо хэмжээ С ширхэг
50	0
51-150	1
151-1000	2
1001-2000	3
2001-3500	4
3501-5000	5
5001-ээс дээш	N-ээс 0,1 хувиар

**САВ, БАГЛАА БООДОЛТОЙ САВЛАСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТООН ХЭМЖЭЭНД
ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАЙЛАН №**

Шалгалтыг _____
(шалгалт хийсэн эрх бүхий байгууллагын нэр)

Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч
_____ ОВОГТОЙ _____

202..оны ... дугаар ... сарын ... ны өдөр хийв.

Шалгалтад _____
(шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

_____ (шалгалтад хамрагдсан савласан бүтээгдэхүүний нэр, цувралын хэмжээ)

Шалгалтын үр дүнд эвдэрсэн сав баглааны _____
Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хэвийн утга М (г, мл) _____

Тоон хэмжээний хэвийн утгын зөвшөөрөгдөх хэлбэлзлийн утга Т(г,мл) 5-10%

Түүвэр дэх сав, боодлын тоо хэмжээ n _____

Түүвэр дэх тэнцэхгүй сав, баглаа боодлын зөвшөөрөгдөх тоо С 1-3

Сав, баглаа боодлын дундаж жин _____

Хяналтын хэмжилтийг _____

_____ (хэмжих хэрэгслийн нэр, маяг, хэмжлийн хязгаар, үнэмлэхүй алдаа, хэмжилт хийсэн он сар өдөр)

Хэмжлийн үнэмлэхүй алдааг зөвшөөрөгдөх хэлбэлзэлд харьцуулсан харьцаа δ/T %, % - $\delta/T > 1/5$ бол хэмжлийн алдааг ихсэх үндэслэлийг бичнэ.

1. Сав, баглаа боодол тус бүрдэх тоон хэмжээ (г, мл)

Сав, баглаа боодлын дэс дугаар						
Бүтээгдэхүүний тоо хэмжээ (г, мл)						

2. Хэмжлийн үр дүнгийн боловсруулалт:

3. Шалгалтын үр дүнд гарсан дүгнэлт

3.1. _____

3.2. _____

3.3. _____

Шалгалтын ахлагч, улсын байцаагч:

овог нэр

гарын үсэг

Шалгалтад оролцсон:

(ажил, албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

Шалгалтын тайлантай танилцсан аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага :

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог нэр)

..... –д хийсэн сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний
тоон хэмжээний хяналт шалгалтын ажлын үр дүн

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

Бүтээгдэхүүний нэр _____

Түүврийн хэмжээ _____ ширхэг

Зөвшөөрөх хэлбэлзэл Т _____ г,(мл)

Цэвэр тоон хэмжээ _____ г,(мл)

n	x	n	x	n	x	n	x	n	x
1.		26		51		76		101	
2.		27		52		77		102	
3.		28		53		78		103	
4.		29		54		79		104	
5.		30		55		80		105	
6.		31		56		81		106	
7.		32		57		82		107	
8.		33		58		83		108	
9.		34		59		84		109	
10.		35		60		85		110	
11.		36		61		86		111	
12.		37		62		87		112	
13.		38		63		88		113	
14.		39		64		89		114	
15.		40		65		90		115	
16.		41		66		91		116	
17.		42		67		92		117	
18.		43		68		93		118	
19.		44		69		94		119	
20.		45		70		95		120	
21.		46		71		96		121	
22.		47		72		97		122	
23.		48		73		98		123	
24.		49		74		99		124	
25.		50		75		100		125	

Σх- цувралийн дундаж хэмжээ

Шалгалт хийсэн улсын байцаагч:

**Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт шалгалт
хийхэд ашиглах ажлын эталон жингийн техникийн үзүүлэлт**

Сав, боодолтой бүтээгдэхүүний Бодит жин (г)	Жингийн хуваарийн хуваагдлын нэгж (г)
25 хүртэл	0,01
25-1000	0,1
1000-5000	1,0
5000-аасдээш	2,0

Жич: Сав баглаа боодолтой бүтээгдэхүүний тоон хэмжээний хяналт шалгалт хийхэд ашиглах жингийн хуваарийн хуваагдлын нэгж нь уг сав, баглаа боодолтой бүтээгдэхүүний хамгийн бага зөвшөөрөх алдааны хэлбэлзэлтэй тэнцүү байхыг зөвшөөрнө.

----oOo----